



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

66

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 176 дахь заалт, Цахим эрүүл мэнд стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Телемедицинний үндэсний сүлжээний ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай
3. Журмын хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 372 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

Н.УДВАЛ



Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 09 дугаар сарын 11-ны  
өдрийн 330 дүгээр тушаалын  
хавсралт

## ТЕЛЕМЕДИЦИННИЙ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭНИЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

### **Нэг. Нийтлэг зүйл**

#### **1.1 Үндэслэл, хууль эрх зүйн орчин**

“Эрүүл мэндийн тухай” хуулийн 4.2.1. Цахим эрүүл мэндийн стратеги, Эрүүл мэндийн сайдын “Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын журам батлах тухай” 2009 оны 357 дугаар тушаал, “Эрүүл мэндийн технологийн нэгдсэнбодлого батлах тухай” 2013 оны 176 дугаар тушаалыг тус тус үндэслэн боловсруулав.

Телемедицинний үндэсний сүлжээнд холбогдсон эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн тусlamжтайгаар төрөлжсөн мэргэжлийн зөвлөгөө өгөх, оношлохуйлчилгээ үзүүлэх, төгсөлтийн дараах сургалтыг зайнаас зохион байгуулах, цахим мэдээлэл цуглуулах үйл ажиллагаандaa энэхүү журмыг мөрдлөг болгоно.

#### **1.2 Нэр томъёоны тодорхойлолт**

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1 “**Телемедицин**” гэж харилцаа холбооны болон мэдээллийн технологийг ашиглан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг зайнаас үзүүлэхтехнологийг;

1.2.2 “**Телемедицинний үйлчилгээ**” гэж телемедициний тоног төхөөрөмж байрлах, интэрнетийн сүлжээ бүхий өрөө, сүлжээнд холбогдон ажиллах тоног төхөөрөмж, програм хангамжийг ашиглан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг зайнаас үзүүлэх үйлчилгээг;

1.2.3 “**Телемедицинний үндэсний сүлжээ**” гэж нэгдсэн удирдлага, зохицуулалт бүхийтелемедициний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэгдлийг;

1.2.4 “**Телемедицинний програм хангамж**” гэж телемедициний үйлчилгээндашиглагдах програм хангамжийг;

1.2.5 “**Идэвхтэй /онлайн/ үйлчилгээ**” гэж телемедициний үйлчилгээ үзүүлэгч талууд цаг хугацаанынэг агшинд зэрэг холбогдох үйлчилгээг;

1.2.6 “**Идэвхгүй /офлайн/ үйлчилгээ**” гэж телемедициний үйлчилгээ үзүүлэгч талууд цаг хугацааны хамааралгүйгээр телемедициний програмхангамж ашиглан харилцан холбогдох үйлчилгээг;

1.2.7 “**Телемедицинний техник, тоног төхөөрөмж**” гэж телемедициний үйлчилгээг үзүүлэхэд зориулагдсанундсэн болон дагалдахтехник хэрэгслийг;

1.2.8 “**Телемедицинний төрөлжсөн төв**” гэж телемедициний үндэсний сүлжээг ашиглан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, оношилгоо хийх чадвар бүхий Эрүүл мэндийн яамны харъяатусгай мэргэжлийн төв, төв эмнэлгүүдийг;

1.2.9 “**Телемедицинний үндэсний сүлжээний зохион байгуулагч/администратор/**” гэж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн телемедициний албаны мэдээллийн технологийн мэргэжилтэнг;

1.2.10 “Телемедициний үйлчилгээ зохицуулаагч” гэж телемедициний үйлчилгээ зохион байгуулж буй эрүүл мэндийн байгууллагын телемедициний зөвлөгөө, сургалт, судалгаа, мэдээний сан хариуцсан мэргэжилтэнг;

1.2.11 “Телемедициний инженер” гэжэрүүл мэндийн байгууллагуудын телемедицин хариуцсан мэдээллийн технологийн ажилтанг;

1.2.12 “Зөвлөгч” гэж телемедициний сүлжээ ашигланоношилгоо, эмчилгээний талаар зөвлөгөө өгч буй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг;

1.2.13 “Захиалагч” гэж телемедициний сүлжээ ашиглан оношилгоо, эмчилгээний талаар зөвлөгөө авах, сургалт зохион байгуулахаар захиалга өгч, үйлчилгээ авч буйбайгууллага, албан тушаалтанг.

**Хоёр. Телемедициний үндэсний сүлжээний байгууллагын үйл ажиллагаандаа баримтлах зарчим, телемедициний үйлчилгээний тэргүүлэх чиглэл**

## 2.1. Телемедициний үйлчилгээг үзүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

2.1.1. Телемедициний үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангаж ажиллана.

2.1.2. Телемедициний үйлчилгээ нь хүн амд тэгш, хүртээмжтэй, хэрэгцээнд нийцсэн, мэргэжлийн тусламж үйлчилгээнд суурилсан байна.

2.1.3. Телемедициний үйлчилгээ үзүүлэхдээ эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтална.

2.1.4. Өвчтөний аюулгүй байдал, нууцлал, эрхийг хангаж үйлчилнэ.

## 2.2. Телемедициний үндэсний сүлжээний байгууллагууд нь дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээнд телемедициний технологийг нэн түрүүнд ашиглана:

2.2.1. Тархи, нуруу нугас, цээж, хэвлийн хөндийн гэмтлийн тусламж;

2.2.2. Цээж, хэвлийн хөндийн мэс заслын тусламж;

2.2.3. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж;

2.2.4. Нярай ба 5 хуртлэх наслын хүүхдийн эмнэлгийн тусламж.

2.2.5. Зүрх, судасны эмгэгийн оношилгоо, эмчилгээ

2.2.6. Төрөлхийн гаж хөгжлийн оношилгоо, эмчилгээ

2.2.7. Эмгэг судлалын шинжилгээ

**Гурав. Телемедициний үндэсний сүлжээний үйл ажиллагаанд тавигдахшаардлага**

### 3.1. Телемедициний үйлчилгээ явуулах өрөөнд тавигдах шаардлага

3.1.1. Телемедициний үндэсний сүлжээнд холбогдсон байгууллага нь яаралтай зөвлөгөө өгөх, авах боломж бүхий тусгай зориулалтын өрөөтэй байна.

3.1.2. Энэхүү журамд заагдсан телемедициний үйлчилгээ явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

3.1.3. Өрөөний төлөвлөлтийг нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний албатайзөвлөж хийнэ.

3.1.4. Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг сайтай байна.

3.1.5. 24 цагаартелемедициний үйлчилгээг явуулах интернетийн сүлжээтэй байна.

3.1.6. Цахилгааны нөөц эх үүсвэртэй байна.

### **3.2. Тоног төхөөрөмжийн ашиглалтад тавигдах шаардлага**

3.2.1. Телемедицинний тоног төхөөрөмж нь телемедициний өрөө болон яаралтай тусламжийн өрөө хооронд зөөвөрлөж болохоор хөдөлгөөнт төхөөрөмжинд суурилуулагдсан байна.

3.2.2. Телемедицинний дуранг үйлчилгээнд оролцогчдын үйл ажиллагаанд бэрхшээл учруулахгүйгээр байрлуулсан байна.

3.2.3. Телемедициний програм хангамж болон бусад тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан тохилдолд тухайн эрүүл мэндийн байгууллага нь тоног төхөөрөмж нийлүүлэгч байгууллага болон мэдээллийн технологийн мэргэжлийн байгууллагадмэдэгдэжшуурхайзасварлан хэвийн үйл ажиллагаандоруулах арга хэмжээ авна.

3.2.4. Телемедициний тоног төхөөрөмжийн үзүүлэлт нь тухайн байгууллагын телемедициний үндэсний сүлжээнд гүйцэтгэх чиг үүргийн шаардлагыг хангахуйц байна.

### **3.3. Програм хангамжид тавигдах шаардлага**

3.3.1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 тоот тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журмын 5 дугаар бүлэгт тусгасан шаардлагуудыг хангасан байна.

3.3.2. Програм хангамж нь хэрэглэхэдхялбар, энгийн бүтэцтэйбайна.

3.3.3. Эмнэлзүйн өдөр дутмын үйл ажиллагаанд нийцсэн байна.

3.3.4. Програмд нэвтрэхнэр, нууцүүгийг хэрэглэгчид тус бүрт үүсгэх боломжтой байна.

3.3.5. Цаашид өргөтгөл хийж хөгжүүлэх боломжтой байна.

### **3.4. Телемедициний үйлчилгээний мэдээллийн нууцлалд тавигдах шаардлага**

3.4.1. Телемедициний тусламж, үйлчилгээний мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахдаа "Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2009 оны 357 тоот тушаалыг баримталж ажиллана.

3.4.2. Телемедициний тусламж үйлчилгээ үзүүлэгч нь тусламж үйлчилгээнийнээлттэй мэдээллийг өөрчлөх, устгах, хязгаарлагдмал болон нууц мэдээллийг бусдад дамжуулах, өөрчлөхийг хориглоно.

3.4.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний алба нь үйлчлүүлэгчийн зайн оношилгоо, эмчилгээний талаарх мэдээллийг цахим хэлбэрээр нөөцлөн хадгалж, аюулгүй байдлыг хангана.

3.4.4. Хязгаарлагдмал болон нууц цахим мэдээллийг дамжуулах үед тухайн файлыг нууц үгээр хамгаална. Нууц үг нь "Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2009 оны 357 тоот тушаалд нийцсэн байна.

3.4.5. Цахим мэдээллийн агуулгыг хамгаалах үүднээс програм хангамжийн түвшинд өөрчлөх (засах, нэмэх, устгах) боломжийг тодорхой эрхээр хязгаарласан байна.

### **3.5. Телемедициний үндэсний сүлжээ зохион байгуулагчийн эрх, үүрэг**

3.5.1. Телемедициний үндэсний сүлжээнд ашиглагдах програм хангамжийг судалж, санхүүжилтийг байгууллагынхаа тухайн жилийн төсөвт тусгуулж, програм хангамжийн үйл ажиллагаанд хяналт тавина.

3.5.2. Телемедициний үндэсний сүлжээний програм хангамж, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангана.

3.5.3. Орчин үеийн шинэ технологийг судлан хэрэглэгчид түгээж, нэвтрүүлнэ.

3.5.4. Телемедицинний үндэсний сүлжээ, програм хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сургалт зохион байгуулах, гарын авлага, материалыг боловсруулна.

3.5.5. Төлөмединий инженерт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

3.5.6. Нэн яаралтай зөвлөгөө, эмчилгээний үед үндэсний сүлжээний бэлэн байдлыг хангана.

3.5.7. Телемедицинний үндэсний сүлжээнд холбогдон ажилласан талаарх бичлэг болон холбогдох баримтыг CD болон DVD дээр хуubarланулирал бүр архивлан хадгалана.

3.5.8. Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан хийгдсэн зөвлөгөө, эмчилгээний талаарх мэдээлэл, бичлэгийг эрх бүхий удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр бусдад дур мэдэн дамжуулахгүй.

### **3.6. Телемедицинний инженерийн эрх, үүрэг**

3.6.1. Байгууллагынхаа телемедициний тоног төхөөрөмжийг хариуцаж, хэвийн үйл ажиллагаа, бэлэн байдлыг хангана.

3.6.2. Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан явуулах сургалт, зөвлөгөө, эмчилгээний хуваарийг сар тутам гаргаж, Телемедициний үйлчилгээ зохицуулагчид мэдээлнэ.

3.6.3. Баримт бичгийн дижитал камер, рентген хальсны зургийг тоон системд хөрвүүлэгч сканнер ашиглан өвчтөний талаарх мэдээллийг захиалагчтай хамтранблэлтгэнэ.

3.6.4. Телемедицинний үндэсний сүлжээний интернетийн болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг байгууллагын төсөвт тусгах асуудлыг удирдлагадаа тавьж шийдвэрлүүлнэ.

3.6.5. Телемедицинний үйлчилгээний тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс өөрийн орлон ажиллах мэргэжилтнийг байгууллагын удирдлагын шийдвэрээр томилуулсан байна.

3.6.6. Төлөмединий үндэсний сүлжээ ашиглалтын талаарх сургалт, зөвлөгөөг телемедициний үйлчилгээ зохицуулагчаас авна.

3.6.7. Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан хийгдсэн зөвлөгөө, эмчилгээний талаарх мэдээлэл, бичлэгийг эрх бүхий удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр бусдад дур мэдэн дамжуулахгүй.

3.6.8. Шаардлагатай тохиолдолд телемедициний төхөөрөмжийгтасаг хооронд зөөвөрлөх нөхцлийг хангана.

### **3.7. Телемедицинний үйлчилгээ зохицуулагчийн эрх, үүрэг**

3.7.1. Яаралтай оношилгоо, эмчилгээний үед өвчний түүх болон шаардлагатай шинжилгээний хариуг харуулах, төгсөлтийн дараах зайны сургалтыг явуулах нөхцлийг хангана.

3.7.2. Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан явуулах бүх сургалт, зөвлөгөө, эмчилгээний төлөвлөгөө, хуваарийг сар бүр гаргах, бүртгэх, зохион байгуулах, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангана.

3.7.3. Телемедицинний сүлжээний үйл ажиллагааны мэдээний санг бий болгож, баяжуулах, бусад мэдээний сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.7.4. Аливаа мэдээллийн нууцыг хангаж ажиллана.

3.7.5. Хичээлийн агуулга, сэдэвт хяналт тавих ба хичээлийндурс бичлэгийг архивлан хадгалах ажлыг зохион байгуулна.

### **3.8. Зөвлөгчийн эрх, үүрэг**

3.8.1. Зөвлөгч ньмэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна.

3.8.2. Зөвлөгөө өгч буй мэргэжлийн чиглэлээр тэргүүлэх болон түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй, эрдмийн цолтой, телемедицинний төрөлжсөн төв эсвэл бусийн оношилгоо эмчилгээний төвд харьялалтай байна.

3.8.3. Гадаадын эмч, эмнэлгийн мэргэжилтнээс зөвлөгөө авах тохиолдолд зөвлөгч нь Монгол Улсын эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаж байсан туршлагатай байна.

### **3.9. Захиалагчийн эрх, үүрэг**

3.9.1. Телемедицинний үйлчилгээ ашиглан өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар зөвлөгөө авахад шаардагдах мэдээлэл /өвчний түүх, өөрийн тавьсан онош, хийгдсэн шинжилгээний хариу/-ийг телемедицинний үйлчилгээнд тохируулан чанартай бэлтгэнэ.

3.9.2. Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авах төрөлжсөн мэргэжлийн чиглэлийн саналаа Телемедицинний үйлчилгээ зохицуулагчидтодорхой гаргажегнэ.

3.9.3. Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан эмнэлгийн яаралтай тусламжийн чиглэлээр зөвлөгөө авах тохиолдолд өвчтөнөө бэлтгэнэ.

3.9.4. Зөвлөгчийн өгсөн зөвлөгөөгөвчтөний эмчилгээндашигах эсэхийг захиалагч талшийдэх бөгөөд эмчилгээний үр дунг бие даан хариуцана.

3.9.5. Телемедицинний сүлжээ ашиглан хийгдсэн зөвлөгөө, эмчилгээний талаарх мэдээлэл, бичлэгийг эрх бүхий удирдах албан тушаалтны шийдвэрлгүйгээр бусдад дур мэдэн дамжуулахгүй.

### **3.10. Хичээл заах багшид тавигдах шаардлага**

3.10.1. Багш нь сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагын үндсэн ажилтан байх, аль эсвэл эдгээр байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.


3.10.2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиалгаар хичээлийг холбогдох тушаал, журамд заасны дагуу онол болон дадлагын хэлбэрээр бэлтгэх туршлагатай, заах арга зүй эзэмшсэн байна.

3.10.3. Өөрийн мэргэжлийн чиглэлээр явуулсан сургалттай холбоотой асуудлыг холбогдох байгууллагын өмнө хариуцана.

## **Дөрөв. Телемедициний үндэсний сүлжээний бүтэц, үйл ажиллагаа**


4.1 Телемедицинний үндэсний сүлжээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн Телемедицинний алба (ТМА), Улсын нэгдүгээр төв эмнэлэг (УНТЭ), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ), Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ), Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ), Гэмтэл, согог судлалын үндэсний төв (ГССҮТ), Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ), Эмгэг судлалын үндэсний төв (ЭСҮТ), Арьсны өвчин судлалын үндэсний төв (АӨСҮТ), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ) болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (БОЭТ), аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эмнэлэг холбогдож ажиллана.

### Телемедицинний үндэсний сүлжээний бүтэц



**Тав. Телемедицинний сүлжээний байгууллагуудын үйл ажиллагааны дүрэм**


#### 5.1 “Идэвхтэй сүлжээний /онлайн/ үйлчилгээ”-ний горим



5.1.1 “Идэвхтэй /онлайн/ үйлчилгээ” нь видео хурлын төхөөрөмжийг ашиглан явагдахаар зохион байгуулагдана.

5.1.2 “Идэвхтэй /онлайн/ үйлчилгээ” –ний горимыг зөвхөн эмнэлгийн тусламж үйлчилгээнд бус эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах онлайн сургалт, хурал, зөвлөгөөн зохион байгуулахад ашиглана.


## 5.2 “Идэвхгүй /оффлайн/ үйлчилгээ”-ний горим



5.2.1 “Идэвхгүй /оффлайн/ үйлчилгээ” нь энэхүү журмын 3.3-д заасан шаардлагыг хангасанпрограмыг ашиглан зөвлөгч эмчээс зөвлөгөө авахаар зохион байгуулагдана.

5.2.2 “Идэвхгүй /оффлайн/ үйлчилгээ” –ний горимыг зөвхөн эмнэлгийн тусламж үйлчилгээнд бус эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, төрөл бүрийн цахим мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулахад ашиглана.

### 5.3 Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан үзүүлэх тусламж, үйлчилгээний шатлал



Тайлбар:

- Зөвлөгөө авах хүсэлт илгээж буй байгууллагад тухайн чиглэлээр мэргэшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн байхгүй тохиолдолдараагийн шатлалын байгууллагад хүсэлт илгээн тусламж үйлчилгээ авна.
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн телемедицинний алба, телемедицинний төрөлжсөн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд идэвхитэй үйлчилгээний, сум дундын эмнэлэг болон сумын эрүүл мэндийн төвүүд нь идэвхигүй үйлчилгээний горимоор телемедицинний үндэсний сүлжээнд орж ажиллана.
- Техник, технологийн шинэчлэл хийсний дараа телемедицинний үйлчилгээний горимыг өөрчилж ажиллах саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедицинний албанад тавьж шийдвэр гаргуулан сольж болно.

**Зургаа.. Телемедициний үндэсний сүлжээний байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиглэл, хүлээх үүрэг**

#### 6.1. Телемедицинний албаны үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүрэг

Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний албаны телемедицинтэй холбоотой бүх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд мэргэжлийн нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган, чиглүүлэх дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана.

6.1.1. Телемедицинний алба нь эрүүл мэндийн байгууллага хоорондын телемедициний үйл ажиллагааг зохицуулж, оношилгоо эмчилгээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхээр телемедициний төрөлжсөн төв /ПТТ/-үүдээс өгөх зөвлөгөө, эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах зайны сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

6.1.2. Телемедициний алба нь телемедициний техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон үзүүлалтын өрөө, хөдөлгөөнт зайн оношилгооны баг, мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байна.

6.1.3. Телемедициний алба нь телемедициний үндэсний сүлжээний үйл ажиллагаанд жил бүр хяналт-үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулна.

6.1.4. Ажлын бус цагаар телемедицин ашиглан зөвлөгөө, оношилгооны үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, зайн сургалтын багшийн ажилласан цагийн хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу тооцож олгуулах ажлыг зохион байгуулна.

6.1.5. Төлемедициний алба нь телемедициний сүлжээний техник, технологийг ашиглан тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлүүлэх өвчин эмгэгийн жагсаалтыг гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулна.

6.1.6. Телемедициний үндэсний сүлжээний байгууллагуудын техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавих, техник, тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад байгууллагатай хамтран ажиллана.

6.1.7. Телемедициний сүлжээнд холбогдон ажилласан талаарх бичлэг болон холбогдох баримтыг Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 тоот тушаалын дагуу хадгална.

6.1.8. Телемедициний алба нь телемедициний үйлчилгээ үзүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зайнлас зохион байгуулах чиглэлээр олон улсын болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

6.1.9. Монгол Улсад телемедициний чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог ханган, улирал бүр тайлан мэдээг хүлээн авч нэгтгэнэ.

6.1.10. Телемедициний албаны тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Full HD - LCD дэлгэц	<ul style="list-style-type: none"> <li>- 65 инчээс багагүй.</li> <li>- Full HD 1080p resolution</li> <li>- 150,000:1 Dynamic Contrast Ratio</li> <li>- USB 2.0 (jpeg, mp3, DivX HD)</li> <li>- RGB, DVI, HDMI оролттой.</li> </ul>
2	Видео хурлын тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- HD camera</li> <li>- HD audio</li> <li>- External audio, Video &amp; DataInput/Output: Audio:5 in, 4 out video:2 in, 2 out</li> <li>- Point to multipoint HD Video communication</li> </ul>

3	Компьютер	<ul style="list-style-type: none"> <li>- Core i5 2.93 Ghz CPU – ээс багагүй</li> <li>- 4GB RAM</li> <li>- 500GBHDD</li> <li>- 22" LCD monitor</li> <li>- 1GB Video card</li> <li>- Keyboard, mouse</li> <li>- Windows 7-с болон түүнээс дээш үйлдлийн систем</li> </ul>
4	HD вэб камер	
5	Тог баригч	<ul style="list-style-type: none"> <li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V, SmartSlot USB /</li> <li>- Includes: CD with software, UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li> </ul>
6	Сервер	<ul style="list-style-type: none"> <li>- 1TB-аас дээш багтаамжтай</li> <li>- 6GB-аас дээш шуурхай санах ойтой</li> <li>- Administrator control: системийг удирдах, бичлэг хийх хадгалах</li> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- AC 120/230 V</li> <li>- Дотоод сүлжээнд холбогддог</li> </ul>

## 6.2. Телемедицинний төрөлжсөн төвийнүйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг

Телемедицинний төрөлжсөн төв нь өөрийн чиг үүргийн дагуу зайнлас зөвлөгөөгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэхзайн сургалт зохион байгуулах, теле-хуралд оролцох үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана. Үүнд:

6.2.1. Телемедицинний төрөлжсөн төвны телемедициний сүлжээний техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон зориулалтын өрөө, мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байна.

6.2.2. Телемедицинний үйлчилгээнд оролцох болон уг үүргийг орлон гүйцэтгэх төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийн ажиллах хуваарь, гэрийн хаяг, утасны жагсаалтын хамт мэргэжил бүрээр гаргаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедицинний албанад ирүүлэх ба улирал бүр шинэчилж, тухай бүр мэдээлэх үүргийг төрөлжсөн мэргэжлийн төв, төв эмнэлгийн захирал, дарга нар хүлээнэ.

6.2.3. Телемедицинний үндэсний сүлжээг ашиглан өвчтөний оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх шаардлага гарсан даруйд телемедицинний төрөлжсөн төвийнэмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, түүний зэгүйд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын менежер холбогдох ажил үйлчилгээг зохион байгуулна.

6.2.4. Сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан албан тушаалтан нь Телемедицинний үндэсний сүлжээ ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг мэргэжлийн чиглэлийн дагуу зохион байгуулах асуудлыг хариуцна.

6.2.5. Телемедицинний төрөлжсөн төв нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедицинний албатай хамтрангадаадын төрөлжсөн мэргэжлийн төвүүдтэй харилцаж өвчтний оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааг явуулна.

6.2.6. Алслагдсан эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс илгээх хөдөлгөөнт зайн оношилгооны багт төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг оролцуулна.

6.2.7. Интернетийн төлбөр болон телемедициний техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ажлын бус цагаар телемедицин ашиглан зөвлөгөө, оношилгооны үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, зайн сургалтын багшийн ажилласан цагийн хөлстэй холбоотой зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт суулгана.

6.2.8. Телемедициний төрөлжсөн төв (ҮНТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, ГССҮТ, УГТЭ, ЭСҮТ, АӨСҮТ, ЗӨСҮТ)-ийн удирдлагууд төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, оношилгоо, эмчилгээ, эмч, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг телемедициний үндэсний сүлжээ ашиглан зайнаас шийдвэрлэх үйл ажиллагааг дараах чиглэлийн дагуу тус тусын байгууллага дээр зохион байгуулж ажиллана. Үүнд:

Телемедициний төрөлжсөн төв	Зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудал шийдвэрлэх мэргэжлийн чиглэл
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	<ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхий мэс засал</li> <li>• Урологи, проктологи</li> <li>• Бөөр</li> <li>• Цус</li> <li>• Дотоод шүүрэл</li> </ul>
Улсын гуравдугаар төв эмнэлэг	<ul style="list-style-type: none"> <li>• Зүрх, судас</li> <li>• Мэдрэл</li> <li>• Уушиг</li> </ul>
Гэмтэл, согог судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Гэмтэл</li> <li>• Согог засал</li> </ul>
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Эх барих, эмэгтэйчүүд</li> <li>• Хүүхэд</li> <li>• Хүүхдийн мэс засал</li> </ul>
Халдварт өвчин судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Халдварт өвчин</li> </ul>
Хавдар судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Хавдар</li> </ul>
Арьсны өвчин судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Арьсны өвчин</li> </ul>
Зоонозын өвчин судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Зоонозын өвчин</li> </ul>
Эмгэг судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> <li>• Эмгэг судлал</li> </ul>

6.2.9. Телемедициний төрөлжсөн төвийн телемедициний сүлжээний тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Full HD - LCD дэлгэц	<ul style="list-style-type: none"> <li>- 42 инчээс багагүй.</li> <li>- Full HD 1080p resolution</li> <li>- 150,000:1 Dynamic Contrast Ratio</li> <li>- USB 2.0 (jpeg, mp3, DivX HD)</li> <li>- RGB, DVI, HDMI оролттой.</li> </ul>
2	Видео хурлын тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- HD camera</li> <li>- HD audio</li> <li>- External audio, Video &amp; DataInput/Output: Audio: 5 in, 4 out video: 2 in, 2 out</li> <li>- Point to point HD Video communication</li> </ul>
3	Компьютер	<ul style="list-style-type: none"> <li>- Core i5 2.93 Ghz CPU</li> <li>- 4GB RAM</li> <li>- 500GBHDD</li> <li>- 22" LCD monitor</li> <li>- 1GB Video card</li> <li>- Keyboard, mouse</li> <li>- Windows 7-с болон түүнээс дээш үйлдлийн систем</li> </ul>
4	Баримт бичгийн дижитал камер	<ul style="list-style-type: none"> <li>- Image sensor: 1/2.5" CMOS</li> <li>- Pixels count: 5M pixels</li> <li>- Output resolution: full HD 1080p(1920x1080)</li> <li>- Tv lines (HxV): 650x650</li> <li>- Framerate: 30fps</li> <li>- Lens:F3.5; fl=6~60mm</li> <li>- Shooting area: 11.8" x 8.9"</li> <li>- Focus: auto/manual</li> <li>- Zoom: 160x total zoom (12x optical zoom, 13.3x digital zoom)</li> </ul>
5	Рентген хальсны зургийг тоон системд хөрвүүлэгч сканнер	<ul style="list-style-type: none"> <li>- Scanning area: 2.5" x 2.5" min, 14" x 35" max</li> <li>- Scanning speed: 7 seconds @ 300dpi, 14" x 17"</li> <li>- Optical resolution: 600 dpi</li> <li>- Interface: hi-speed usb</li> </ul>
6	Тог баригч	<ul style="list-style-type: none"> <li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V/</li> <li>- Includes: CD with software, UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li> </ul>

### 6.3. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үйл ажиллагааны үндсэнчиглэл, эрх үүрэг

Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь өөрийн харьяа аймгуудын нэгдсэн эмнэлгүүдээс ирүүлсэн захиалгын дагуу зайнаас төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх, зайн сургалт болон төле-хуралд оролцох үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана.

6.3.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь телемедицинний техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон зориулалтын өрөө, хөдөлгөөнт зайн оношилгооны баг, мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байна.

6.3.2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь телемедицинний төрөлжсөн төв болон бусад эрүүл мэндийн байгууллага, эмнэлгээстелемедициний үйлчилгээ авах тохиолдолд хэлэлцэх өвчтөний тухай мэдээллийг зөвлөгөө эхлэхээс 1 цагаас багагүй хугацааны өмнө холбогдох байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ирүүлсэн байна.

6.3.3. Телемедициний үйлчилгээний талаар сар бүр статистик тайлан мэдээ гаргаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний албанад ирүүлнэ.

6.3.4. Телемедициний үндэсний сүлжээнд холбогдон ажилласан талаарх бичлэг болон холбогдох баримтыг Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 тоот тушаалын дагуу хадгална.

6.3.5. Телемедициний үндэсний сүлжээ ашиглан гадаадын төрөлжсөн мэргэжлийн төвүүдтэй харилцаж өвчтний оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний албатай хамтран зохион байгуулна.

6.3.6. Интернетийн төлбөр болон телемедицинний техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ажлын бус цагаар телемедицин ашиглан зөвлөгөө, оношилгооны үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, зайн сургалтын багшийн ажилласан цагийн хөлстэй холбоотой зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгана.

6.3.7. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн телемедициний сүлжээний тоногтөхөөрөмжийн техникийн үзүүлэлт нь доорх шаардлагыг хангасан байна.  
Үүнд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Full HD - LCD дэлгэц	<ul style="list-style-type: none"> <li>- 42 инчээс багагүй.</li> <li>- Full HD 1080p resolution</li> <li>- 150,000:1 Dynamic Contrast Ratio</li> <li>- USB 2.0 (jpeg, mp3, DivX HD)</li> <li>- RGB, DVI, HDMI оролттой.</li> </ul>
2	Видео хурлын тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- HD camera</li> <li>- HD audio</li> <li>- External audio, Video &amp; DataInput/Output: Audio:5 in, 4 out video:2 in, 2 out</li> <li>- Point to point HD Video communication</li> </ul>

3	Компьютер	<ul style="list-style-type: none"> <li>- Core i5 2.93 Ghz CPU</li> <li>- 4GB RAM</li> <li>- 500GBHDD</li> <li>- 22" LCD monitor</li> <li>- 1GB Video card</li> <li>- Keyboard, mouse</li> <li>- Windows 7-с болон түүнээс дээш уйлдлийн систем</li> </ul>
4	Баримт бичгийн дижитал камер	<ul style="list-style-type: none"> <li>- Image sensor: 1/2.5" CMOS</li> <li>- Pixels count: 5m pixels</li> <li>- Output resolution: full HD 1080p(1920x1080)</li> <li>- Tv lines (HxV): 650x650</li> <li>- Framerate: 30fps</li> <li>- Lens:F3.5; fl=6~60mm</li> <li>- Shooting area:11.8"x8.9"</li> <li>- Focus: auto/manual</li> <li>- Zoom:160x total zoom (12x optical zoom, 13.3x digital zoom)</li> </ul>
5	Рентген хальсны зургийг тоон системд хөрвүүлэгч сканнер	<ul style="list-style-type: none"> <li>- Scanning area: 2.5"x2.5" min, 14"x35" max</li> <li>- Scanning speed:7 seconds @ 300dpi, 14"x17"</li> <li>- Optical resolution: 600 dpi</li> <li>- Interface: hi-speed usb</li> </ul>
6	Тог баригч	<ul style="list-style-type: none"> <li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V/</li> <li>- Includes: CD with software, Smart UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li> </ul>
7	Сервер	<ul style="list-style-type: none"> <li>- 1TB-аас дээш багтаамжтай</li> <li>- 6GB-аас дээш шуурхай санах ойтой</li> <li>- Administrator control: системийг удирдах, бичлэг хийх хадгалах</li> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- AC 120/230 V</li> <li>- Дотоод сүлжээнд холбогддог</li> </ul>

#### 6.4. Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь харьяа сум дундын эмнэлэг, сумынэрүүл мэндийн төв(ЭМТ)-өөс ирүүлсэн захиалгын дагуу зайнлас төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх, зайн сургалт болон төлөхуралд оролцох үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана.

6.4.1. Аймгийн нэгдсэн эмнэлэг нь телемедицинний техник, тооног төхөөрөмжөөр тооноглогдсон зориулалтын өрөө, мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байна.

6.4.2. Сумын ЭМТ, сум дундын эмнэлгийн хүсэлтийн дагуу телемедицинний үйлчилгээ үзүүлэх шийдвэрийг аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга гаргана.

6.4.3. Аймгийн нэгдсэн эмнэлэг нь бусийн оношилгоо, эмчилгээний төв, телемедицинний төрөлжсөн төвөөстелемедицинний үйлчилгээ авахтохиолдолд хэлэлцэх өвчтөний тухай мэдээллийг зөвлөгөө эхлэхээс 1. цагаас багагүй хугацааны өмнө холбогдох байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ирүүлсэн байна.

6.4.4. Сумын ЭМТ болон сумын дундынэмнэлгийн телемедицинний үйлчилгээний талаарсар бүр статистик тайлан мэдээ нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедицинний албанад ирүүлнэ.

6.4.5. Интернетийн төлбөр болонтелецчиний техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ажлын бус цагаар телемедицин ашиглан зөвлөгөө, оношилгооны үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, зайн сургалтын багшийн ажилласан цагийн хөлстэй холбоотой зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгана.

6.4.6. Аймгийн нэгдсэн эмнэлгийн телемедицинний сүлжээний тоног төхөөрөмж нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Full HD - LCD дэлгэц	<ul style="list-style-type: none"> <li>- 42 инчээс багагүй.</li> <li>- Full HD 1080p resolution</li> <li>- 150,000:1 Dynamic Contrast Ratio</li> <li>- USB 2.0 (jpeg, mp3, DivX HD)</li> <li>- RGB, DVI, HDMI оролттой.</li> </ul>
2	Видео хурлын тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- HD camera</li> <li>- HD audio</li> <li>- External audio, Video &amp; DataInput/Output:Audio:5 in, 4 out video:2 in, 2 out</li> <li>- Point to point HD Video communication</li> </ul>
3	Компьютер	<ul style="list-style-type: none"> <li>- Core i5 2.93 Ghz CPU</li> <li>- 4GB RAM</li> <li>- 500GBHDD</li> <li>- 22" LCD monitor</li> <li>- 1GB Video card</li> <li>- Keyboard, mouse</li> <li>- Windows 7-с болон түүнээс дээш үйлдлийн систем</li> </ul>

82

4	Баримт бичгийн дижитал камер	<ul style="list-style-type: none"> <li>- Image sensor: 1/2.5" CMOS</li> <li>- Pixels count: 5m pixels</li> <li>- Output resolution: full HD 1080p(1920x1080)</li> <li>- Tv lines (HxV): 650x650</li> <li>- Framerate: 30fps</li> <li>- Lens:F3.5; fl=6~60mm</li> <li>- Shooting area:11.8"x8.9"</li> <li>- Focus: auto/manual</li> <li>- Zoom:160x total zoom (12x optical zoom, 13.3x digital zoom)</li> </ul>
5	Рентген хальсны зургийг тоон системд хөрвүүлэгч сканнер	<ul style="list-style-type: none"> <li>- Scanning area: 2.5"x2.5" min, 14"x35" max</li> <li>- Scanning speed: 7 seconds @ 300dpi, 14"x17"</li> <li>- Optical resolution: 600 dpi</li> <li>- Interface: hi-speed usb</li> </ul>
6	Тог баригч	<ul style="list-style-type: none"> <li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V/</li> <li>- Includes: CD with software, UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li> </ul>

### 6.5. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг

Дүүргийн нэгдсэн эмнэлэг нь Телемедицинний төрөлжсөн төвтэй харилцаж зайнаас төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана.

6.5.1. Дүүргийн нэгдсэн эмнэлэг нь телемедицинний сүлжээний техник, тоног төхөөрөмжээр тоноглогдсон зориулалтын өрөө, мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байна.

6.5.2. Дүүргийн нэгдсэн эмнэлэг нь Телемедицинний төрөлжсөн төв болон бусад эрүүл мэндийн байгууллага, эмнэлгээс телемедицинний үйлчилгээ авах тохиолдолд хэлэлцэх өвчтөний тухай мэдээллийг зөвлөгөө эхлэхээс 1 цагаас багагүй хугацааны өмнө холбогдох байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ирүүлсэн байна.

6.5.3. Телемедицинний үйлчилгээний талаар сар бүр статистик тайлан мэдээ гаргаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедицинний албанад ирүүлнэ.

6.5.4. Интернетийн төлбөр болон телемедицинний техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгана.

6.5.5. Дүүргийн нэгдсэн эмнэлгийн телемедицинний сүлжээний тоног төхөөрөмж нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Full HD - LCD дэлгэц	<ul style="list-style-type: none"> <li>- 42 инчээс багагүй.</li> <li>- Full HD 1080p resolution</li> <li>- 150,000:1 Dynamic Contrast Ratio</li> <li>- USB 2.0 (jpeg, mp3, DivX HD)</li> <li>- RGB, DVI, HDMI оролттой.</li> </ul>

2	Видео хурлын тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>- Video quality: Full HD Standards-based 1920x1080-30fps 1280x720-60fps</li> <li>- HD camera</li> <li>- HD audio</li> <li>- External audio, Video &amp; DataInput/Output: Audio: 5 in, 4 out video: 2 in, 2 out</li> <li>- Point to point HD Video communication</li> </ul>
3	Компьютер	<ul style="list-style-type: none"> <li>- Core i5 2.93 Ghz CPU</li> <li>- 4GB RAM</li> <li>- 500GBHDD</li> <li>- 22" LCD monitor</li> <li>- 1GB Video card</li> <li>- Keyboard, mouse</li> <li>- Windows 7-с болон түүнээс дээш үйлдлийн систем</li> </ul>
4	Баримт бичгийн дижитал камер	<ul style="list-style-type: none"> <li>- Image sensor: 1/2.5" CMOS</li> <li>- Pixels count: 5m pixels</li> <li>- Output resolution: full HD 1080p(1920x1080)</li> <li>- Tv lines (HxV): 650x650</li> <li>- Framerate: 30fps</li> <li>- Lens:F3.5; f=6~60mm</li> <li>- Shooting area:11.8"x8.9"</li> <li>- Focus: auto/manual</li> <li>- Zoom:160x total zoom(12x optical zoom, 13.3x digital zoom)</li> </ul>
5	Рентген хальсны зургийг тоон системд хөрвүүлэгч сканнер	<ul style="list-style-type: none"> <li>- Scanning area: 2.5"x2.5" min, 14"x35" max</li> <li>- Scanning speed:7 seconds @ 300dpi, 14"x17"</li> <li>- Optical resolution: 600 dpi</li> <li>- Interface: hi-speed usb</li> </ul>
6	Тог баригч	<ul style="list-style-type: none"> <li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V/</li> <li>- Includes: CD with software, UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li> </ul>

#### **6.6. Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг**

Сум дундын эмнэлэг нь аймгийн нэгдсэн эмнэлэг, бусийн оношилгоо, эмчилгээний төв болон телемедициний төрөлжсөн төвтэй харилцаж зайнаас төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана.

6.6.1. Сум дундын эмнэлэг нь телемедициний сүлжээний техник, тоног төхөөрөмжээр тоноглогдсон зориулалтын өрөө, мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байна.

6.6.2. Сум дундын эмнэлэг нь аймгийн нэгдсэн эмнэлэг, бусийн оношилгоо, эмчилгээний төв, телемедициний төрөлжсөн төв болон бусад эрүүл мэндийн байгууллага, эмнэлгээстелемедициний үйлчилгээ авахтохиолдолд хэлэлцэх өвчтөний тухай мэдээллийг зөвлөгөө эхлэхээс 1 цагаас ихгүй хугацааны өмнө холбогдох байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ирүүлсэн байна.

6.6.3. Телемедициний үйлчилгээний талаар сар бүр статистик тайлан мэдээ гаргаж аймгийн нэгдсэн эмнэлэгт ирүүлнэ.

6.6.4. Интернетийн төлбөр болон телемедициний техник, тоог төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт суулгана.

6.6.5. Сум дундын эмнэлгийн телемедициний сүлжээний тоог төхөөрөмж нь доорх шаардлагаыг хангасан байна. Үүнд:

№	Тоог төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Full HD - LCD дэлгэц	<ul style="list-style-type: none"><li>- 42 инчээс багагүй.</li><li>- Full HD 1080p resolution</li><li>- 150,000:1 Dynamic Contrast Ratio</li><li>- USB 2.0 (jpeg, mp3, DivX HD)</li><li>- RGB, DVI, HDMI оролттой.</li></ul>
2	Видео хурлын тоог төхөөрөмж	<ul style="list-style-type: none"><li>- High-performance smart video™ systems</li><li>- Up to 1080p60 video; 1080p data</li><li>- h.264/SIP(BFCP) dual video</li><li>- Dual HD</li><li>- Tightly integrated with UVC Multipoint/Bridge 2200</li><li>- PTZ 10x or PTZ 4x camera Phone<sup>5</sup>/MicPod</li><li>- Optimized video and data<sup>5</sup></li><li>- Point to point HD Video communication</li></ul>
3	Компьютер	<ul style="list-style-type: none"><li>- Core i5 2.93 Ghz CPU</li><li>- 4GB RAM</li><li>- 500GBHDD</li><li>- 22" LCD monitor</li><li>- 1GB Video card</li><li>- Keyboard, mouse</li><li>- Windows 7-с болон түүнээс дээш үйлдлийн систем</li></ul>
6	Тог баригч	<ul style="list-style-type: none"><li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V/</li><li>- Includes: CD with software, UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li></ul>

#### 6.7. Сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг

Сумын ЭМТ нь Сум дундын эмнэлэг, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Төрөлжсэн мэргэжлийн төвтэйвебд суурилсан програм хангамжийн тусламжтайгаар харилцаж зайнаас төрөлжсэн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгөх, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг хүлээж дараах үндсэн чиглэлээр ажиллана.

6.7.1. Сумын ЭМТ нь техник, тоог төхөөрөмжөөр хангагдаж тухайн тоог төхөөрөмжийг ашиглах талаар аль нэг эмч, эмнэлгийн мэргэжилтнээ сургасан байна.

6.7.2. Сумын ЭМТ нь сум дундын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсэн мэргэжлийн төвөөстелемедициний үйлчилгээ авар тохиолдолд хэлэлцэх өвчтөний тухай мэдээллийг зөвлөгөө эхлэхээс 1 цагаас ихгүй хугацааны өмнө холбогдох байгууллагын эмч, мэргэжилтэнд вебд суурилсан програм хангамжийн тусламжтайгаар ирүүлсэн байна.

6.7.3. Төлемедициний үйлчилгээний талаар сар бүр статистик тайлан мэдээ гаргаж аймгийн нэгдсэн эмнэлэгт ирүүлнэ.

6.7.4. Интернетийн төлбөр болон телемедицинний техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт суулгана.

6.7.5. Сумын ЭМТ-ийн тоног төхөөрөмж нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт /minimum/
1	Компьютер	<ul style="list-style-type: none"> <li>- Core i5 2.93 Ghz CPU</li> <li>- 4GB RAM</li> <li>- 500GBHDD</li> <li>- 22" LCD monitor</li> <li>- 1GB Video card</li> <li>- Keyboard, mouse</li> <li>- Speaker, headphone</li> <li>- Windows 7-с болон түүнээс дээш үйлдлийн систем</li> </ul>
2	Веб камер	<ul style="list-style-type: none"> <li>- Full HD 1080p бичлэг хийх (дээд тал нь 1920 X 1080 pixels) шаардагдах үзүүлэлттэй компьютертэй бол</li> <li>- HD видео холболт (1280 x 720 pixels) шаардлагатай системтэй бол</li> <li>- Carl Zeiss® линз ба автомат фокус</li> <li>- Photos: 5 мегапикселээс багагүй</li> <li>- Микрофон суурьлагдсан байх</li> <li>- Компьютерт холбох залгуур нь Hi-Speed USB2.0</li> </ul>
6	Тог баригч	<ul style="list-style-type: none"> <li>- 670 watts / 1000 VA, Input 230V/ output 230V/</li> <li>- Includes: CD with software, UPS signaling RS-232 cable, USB cable, user manual</li> </ul>

#### Долоо. Телемедициний үндэсний сүлжээний байгууллагуудын хүлээх хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн эмч, мэргэжилтэнд Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Хувь хүн, өвчтөнтэй холбоотой мэдээллийн нууцыг задруулсан албан тушаалтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### Найм. Телемедициний төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах

8.1 Телемедициний төсөл хөтөлбөрүүд нь улирал бүр телемедициний үйлчилгээний үйл ажиллагааны талаарх статистик тайлан мэдээг гаргаж Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Телемедициний албанд ирүүлнэ.